

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв

Аудитын код: САГ-2017/362/13-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас:

Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663, 99117973 Цахим хаяг:

Аудитын менежер: Г.Гүнжидмаа

Утас: 262451, 93014814 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Цэрэндорж

Утас: 261740, 99027789 Цахим хаяг: tserendorj@audit.gov.mn

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	8
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	Error! Bookmark not defined.
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	Error! Bookmark not defined.
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	Error! Bookmark not defined.
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	Error! Bookmark not defined.
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	Error! Bookmark not defined.
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.12	Шилэн дансны мэдээлэл	9
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал	10
3.1	«management_zurchil1»	Error! Bookmark not defined.
3.2	«management_zurchil2»	Error! Bookmark not defined.
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл ..	Error! Bookmark not defined.
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	Error! Bookmark not defined.
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	Error! Bookmark not defined.
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..	Error! Bookmark not defined.
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	Error! Bookmark not defined.
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	Error! Bookmark not defined.

1 Аудитын гэрчилгээ

Баталгаажуулсан гэрчилгээг сканнердаж оруулах


ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Баян тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.24 № 3/333
тантай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

- 2016 оны жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хийгээгүй, үндсэн хөрөнгө 206.2 сая төгрөгөөр нэмэгдсэнээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 119.7 сая төгрөгийн хөрөнгийг тушаал шийдвэргүйгээр балансад бүртгэж тайлагнасан,

\\10.10.10\Bichig_Khuregi\Yawsan_Bichig\2017\0224\SAG18.Docx 07:48

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

- Тайлант онд өглөг 316.6 сая төгрөгөөр нэмэгдэж, 140.4 сая төгрөгийн авлага, 313.1 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.
- 2016 онд 571.0 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө батлагдсанаас, гүйцэтгэлээр 320.0 сая төгрөгийг төлөвлөрүүлж, төлөвлөгөөг 59 хувиар дутуу биелүүлсэн.
- 4.7 сая төгрөгийн ажил гүйлгээний анхан шатны болон санхүүгийн баримтын бүрдэл дутуу, зарим бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй.
- 7.4 сая төгрөгийн шатахууны зардлыг замын хуудсыг үндэслэн тооцоо бодолгүйгээр шууд зардлаар тайлагнасан байна.

Эдгээр нь АОУС-250, Санхүүгийн тайлангийн батламж мэдэлдэлийн Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, УСНББОУС-1, Сангийн сайдын 388, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээр дурдсан зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлж болзошгүй нөлөөллийг эс тооцвол Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б. /21

Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн дарга М.Даваабатад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төвийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 2 дугаар сарын 21-нээс 2017 оны 2 дугаар сарын 23-ны хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Хөдөлмөрийн

аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд ахлах аудитор Д.Цэрэндорж, аудитор Ш.Гүрпүрэв, Ш. Оюунтөгс нар аудит хийв.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2017оны 2 дугаар сарын 02-ны өдрийн 154 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн эрхэм зорилго Орчин үеийн дэвшилтэт технологийг үе шаттай нэвтрүүлж, хөдөлмөрийн нөхцөлийг судлах, үнэлэх, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс сэргийлэх, оншилох, эмчлэх, нөхөн сэргээх үйлчилгээг олон улсын стандартын шаардлагад нийцүүлэн эрдэм шинжилгээ, сургалт судалгаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй байдлыг сайжруулж, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бууруулахад оршино.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв дээрх хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхэлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ. Үүнд:

Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ, мэргэжлээс шалтгаалсан өвчний төвшинг тогтоон, хөдөлмөр зохицуулалт хийх, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан нөхцөлийг судлах, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох, эмчлэн сувилах үйл ажиллагаа юм.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төв санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Acolous” програм хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 1 асуудал эрсдэл дунд зэрэг байна гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 3 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 1 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг шалгах аудитын

горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн -ийг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын дүнг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь илүү бодитой гэж үзэж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төвийн 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардал 1,861.6 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 37.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь илүү бодитой гэж үзлээ.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 5 чиглэлээр 7 эрсдэлтэй асуудалд 5 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 100 хувь буюу 7 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	5	613.7	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	5	613.7	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 1,551.7 сая төгрөг баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,551.7	1,290.0	83.1	261.7
1.1	Урсгал зардал	1,551.7	1,290.0	83.1	261.7
1.2	Хөрөнгийн зардал	0	0	0.0%	0.0

Төсөвт зардлын гүйцэтгэл 83.1 хувь байна.

Тайлант хугацаанд төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогын биелэлт 56.0 хувь байгаа нь орлогын төлөвлөгөөг дутуу биелүүлсэн байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, Улсын төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээг төрийн сангийн шилэн дансны мэдээлэлийг бүрэн оруулж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5 албан шаардлагын биелэлт 2016 оны жилийн эцсийн байдлаар хангалтгүй байна. Мөн 28.3 сая төгрөгний актыг барагдуулаагүй.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “ Хязгаарлалттай ” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс их байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэл болно.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

3.1 ТЭЭВЭР, ШАТХУУНЫ ЗАРДАЛ

Илрүүлэлт

Нийт 7.4 сая төгрөгийн шатахууны зардлыг замын хуудсыг үндэслэн тооцоо бодолгүйгээр шууд зардлын дансанд тусгасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", мөн хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Хариуцах ажилтан

Дарга М.Даваабат
Ерөнхий нягтлан бодогч С.Баяртулга

Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

Эрсдэл

Төсвийн хөрөнгийн үр ашиггүй зарцуулах

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 БАРАА МАТЕРИАЛ

Илрүүлэлт

"Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд" хууль эрх зүйн гарын авлага ном, бусад тараах материал хэвлүүлэхээр дэмжих сангийн 900037025 тоот данснаас 28.8 сая төгрөгийг шилжүүлсэн боловч гэрээ хийсэн гарын авлага номыг хүлээж авсан, тарааж олгосон баримт материалгүй шууд зардлаар тайлагнасан нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна

Хариуцах ажилтан

Дарга М.Даваабат
Ерөнхий нягтлан бодогч С.Баяртулга

Эрсдэл

Төсвийн хөрөнгийн үр ашиггүй зарцуулах

Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3 Үндсэн хөрөнгө

Илрүүлэлт

Тайлант онд үндсэн хөрөнгө 206.2 сая төгрөгөөр нэмэгдсэн боловч Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 119.7 сая төгрөгийн хөрөнгийг тушаал шийдвэргүйгээр балансад бүртгэж тайлагнасан байна. Үндсэн хөрөнгийн тооллогыг тайлант хугацаанд хийж дуусгаагүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй байна, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д "Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг хийнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Хариуцах ажилтан

Дарга М.Даваабат
Ерөнхий нягтлан бодогч С.Баяртулга

Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

Эрсдэл

Үндсэн хөрөнгө үндэслэлгүйгээр нэмэгдэх, хасагдах

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.4 АНХАН ШАТНЫ БАРИМТ

Илрүүлэлт

Тус төвийн 2016 оны санхүүгийн тайланд аудит хийхэд 2.9 сая төгрөгийн ажил гүйлгээний анхан шатны болон санхүүгийн баримтын бүрдэл дутуу, зарим бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

Хариуцах ажилтан

Дарга М.Даваабат
Ерөнхий нягтлан бодогч С.Баяртулга

Эрсдэл

Төсвийн хөрөнгийн үр ашиггүй зарцуулах

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.5 Авлага, өглөг

Илрүүлэлт

2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан 140.4 сая төгрөгийн авлага, 313.1 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй байна.

Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

Хариуцах ажилтан

Дарга М.Даваабат
Ерөнхий нягтлан бодогч С.Баяртулга

Эрсдэл

Авлага, өглөгийн үлдэгдэл буруу илэрхийлэгдэх.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.6 Орлого

Илрүүлэлт

2016 онд 571.0 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө батлагдсанаас, гүйцэтгэлээр 320.0 сая төгрөгийг төлвлөрүүлж төлөвлөгөөг 59 хувиар дутуу биелүүлсэн байна.

Зөвлөмж

Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

Хариуцах ажилтан

Дарга М.Даваабат
Ерөнхий нягтлан бодогч С.Баяртулга

Эрсдэл

Орлогын төлөвлөгөө дутуу биелэх

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Орлого: 16.12.31

	ҮЗҮҮЛЭЛТ		ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	83.20	(83.20)
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,551,728,800.00	1,290,030,357.27	261,698,442.73
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН		1,551,728,800.00	1,290,030,357.27	261,698,442.73
4	Бараа, үйлчилгээний зардал		1,433,912,300.00	1,176,894,591.27	257,017,708.73
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		908,993,200.00	829,735,166.34	79,258,033.66
6	Үндсэн цалин		873,419,200.00	826,770,666.34	46,648,533.66
8	Унаа, болон бусад нөхөн олговор		35,574,000.00	2,964,500.00	32,609,500.00
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		99,989,200.00	32,779,836.00	67,209,364.00
12	Тэтгэврийн даатгал		66,853,500.00	32,779,836.00	34,073,664.00
13	Тэтгэмжийн даатгал		6,627,100.00	-	6,627,100.00
14	ҮОМШО ний даатгал		8,283,900.00	-	8,283,900.00
15	Ажилгүйдлийн даатгал		1,656,800.00	-	1,656,800.00
16	Эрүүл мэндийн даатгал		16,567,900.00	-	16,567,900.00
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		25,689,300.00	16,446,283.00	9,243,017.00
18	Гэрэл цахилгаан		9,185,000.00	6,541,330.00	2,643,670.00
19	Түлш, халаалт		11,104,300.00	5,989,946.00	5,114,354.00
20	Цэвэр, бохир ус		5,400,000.00	3,915,007.00	1,484,993.00
22	Хангамж, бараа материалын зардал		54,623,100.00	51,906,199.93	2,716,900.07
23	Бичиг хэрэг		10,096,400.00	9,710,410.00	385,990.00
24	Тээвэр (шатахуун)		12,571,200.00	12,571,200.00	-
25	Шуудан холбоо, интернэтийн төлбөр		3,515,200.00	3,382,556.93	132,643.07
27	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,897,400.00	1,115,250.00	782,150.00
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс		26,542,900.00	25,126,783.00	1,416,117.00
30	Нормативт зардал		248,185,400.00	181,004,150.00	67,181,250.00
31	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл		232,234,600.00	165,954,150.00	66,280,450.00
32	Хоол, хүнс		965,000.00	50,000.00	915,000.00
33	Нормын хувцас зөөлөн эдлэл		14,985,800.00	15,000,000.00	(14,200.00)
34	Эд хогшил худалдан авах		27,024,200.00	26,618,400.00	405,800.00
35	Багаж, техник, хэрэгсэл		25,469,500.00	21,725,000.00	3,744,500.00
38	Урсгал засвар		1,554,700.00	4,893,400.00	(3,338,700.00)
39	Томилолт, зочны зардал		32,662,700.00	18,507,922.00	14,154,778.00
41	Дотоод албан томилолт		32,662,700.00	18,507,922.00	14,154,778.00
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		36,745,200.00	19,896,634.00	16,848,566.00
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		32,934,200.00	19,244,960.00	13,689,240.00
45	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал		1,500,000.00	-	1,500,000.00
46	Даатгалын үйлчилгээ		1,000,000.00	258,930.00	741,070.00
47	Тээврийн хэрэгслийн татвар		1,000,000.00	283,500.00	716,500.00
48	Тээврийн хэрэгслийн оношилгоо		25,000.00	-	25,000.00
50	Газрын төлбөр		286,000.00	108,944.00	177,056.00
51	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		-	300.00	(300.00)
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		117,816,500.00	113,135,766.00	4,680,734.00
70	Бусад урсгал шилжүүлэг		117,816,500.00	113,135,766.00	4,680,734.00
73	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		20,623,800.00	15,943,066.00	4,680,734.00
76	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		97,192,700.00	97,192,700.00	-
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		1,669,545,300.00	1,406,369,306.00	263,175,994.00
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		1,098,545,300.00	1,086,368,366.00	12,176,934.00
99	Улсын төсвөөс санхүүжих		1,098,545,300.00	1,086,368,366.00	12,176,934.00
106	НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		-	-	-
107	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		-	-	-

110	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		571,000,000.00	320,000,940.00	250,999,060.00
111	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		400,000,000.00	299,095,940.00	100,904,060.00
112	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		171,000,000.00	20,905,000.00	150,095,000.00
120	Нэмэлт санхүүжилтийн орлого		-	-	-
124	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод		-	-	-
125	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болс		-	-	-
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	-	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	-	-
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		-	-	-
130	БАЙГУУЛЛАГЫН ТОО		-	-	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО		1,020.00	58,301.00	(57,281.00)
134	Удирдах ажилтан		555.00	7,878.00	(7,323.00)
135	Гүйцэтгэх ажилтан		455.00	4,545.00	(4,090.00)
136	Үйлчлэх ажилтан		10.00	45,878.00	(45,868.00)
138	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/		-	-	-
148	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО		-	-	-
152	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ		-	-	-
153	Төрийн захиргааны албан хаагч /ТЗ/		-	-	-
154	Төрийн тусгай албан хаагч /ТТ/		-	-	-
155	Ажлын албаны албан хаагч /АА/		-	-	-
156	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч /ТҮБД/		-	-	-
157	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч /ТҮШУ/		-	-	-
158	Соёл урлагын салбарын төрийн үйлчилгээний албан хаагч /ТҮСҮ		-	-	-
159	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч /ТҮ		-	-	-
160	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч /ТҮЗ		-	-	-
161	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/		-	-	-
162	Гэрээт ажилтан		-	-	-
163	Улс төрийн албан хаагч /УТ/		-	-	-

Хувь
-
91.30
91.30
90.91
91.28
94.66
8.33
32.78
49.03
-
-
-
-
64.02
71.22
53.94
72.50
93.81
96.18
100.00
96.23
58.78
92.16
72.93
71.46
5.18
100.09
562.56
85.30
8,381.19
62.79
62.79
54.15
58.43
-
25.89
28.35
-
38.09
-
96.03
96.03
77.30
100.00
91.84
110.77
110.77
-
-

[illegible]